



Инээдний Шинжилгээ

Оросын судлаачид хэдэн ирээдүйтэй зүйлсийг судалж байгаа. Тэдний нэг судалгаа нь инээдний чанарын тухай юм. Энэ судалгаагаар тэд хүний яриаг шинжилж тэндээс инээдийг ялгаж авдаг.

Судлаачид хүний яриаг текст болгодог програмыг хийчихсэн байгаа. “h” болон “a” үсгүүд ээлжлэн дараалан орсон байдлаар үүсэх тэмдэгт мөрийг инээд гэж үздэг. Жишээ нь “ahahaha”, “hah” болон “a” тэмдэгт мөрүүд нь инээд мөн бол “abacaba” болон “hh” тэмдэгт мөрүүд нь инээд биш юм.

Танд текст болгосон s яриаг өгсөн. Инээд гэж тооцож болох хамгийн урт дэд тэмдэгт мөрийн уртыг ол.

Хэрэгжүүлэлтийн мэдээлэл

Та доорх функцийг (аргыг) хэрэгжүүлнэ:

- `int longest_laugh(string s)`. Энэ функц нь s тэмдэгт мөрийн инээд байж болох хамгийн урт дэд тэмдэгт мөрийн уртыг буцаана.

Жишээ

Жишээ 1

- $s = \text{“ahaha”}$

Тэмдэгт мөр бүхэлдээ инээд байгаа тул хариу нь 5 юм.

Жишээ 2

- $s = \text{“ahahrunawayahhsfasthah”}$

Хамгийн урт инээд бүхий дэд тэмдэгт мөр нь “ahah” тул хариу нь 4 юм.

Жишээ 3

- $s = \text{“ahahaahaha”}$

Хамгийн урт инээд бүхий дэд тэмдэгт мөр нь “ahaha” тул хариу нь 5 юм.

Дэд бодлогууд

Энд $|s|$ нь s -ийн урт юм.

1. (21 оноо) $|s| \leq 20$,
2. (26 оноо) $|s| \leq 5000$,
3. (53 оноо) $|s| \leq 10^5$.

Жишээ шалгагч

Жишээ шалгагч нь оролтыг доорх форматаар уншина:

- мөр 1: s тэмдэгт мөр.

Хэлний тайлбар

Өөрийн програмчлалын хэлэн дээрх хэрэгжүүлэлтийн тухай нарийвчилсан мэдээллийг өгөгдсөн загвар файлуудаас олж болно.